



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/64

Хэрлэн сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнд
шинэчлэлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнд шинэчлэлт оруулсугай.

Зөвлөлийн дарга:	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичиг дарга:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Байгаль орчны газрын дарга Нийгмийн даатгалын газрын дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Эрүүл мэндийн газрын дарга Онцгой байдлын газрын дарга Багануур Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн харьяа Хэнтий аймаг дахь салбарын дарга Бор-Өндөр сумын Уулын баяжуулах үйлдвэрийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл /тохиролцсоноор/ “М-Агро” ХХК (тохиролцсоноор хувийн хэвшил)

2.

2.Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/499 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

